

**ОРШИЛ**

Үйл ажиллагааны хүрээнд хүрээлэн буй орчинд учруулах сөрөг нөлөөллийг зөв оновчтой тодорхойлж түүнийг арилгах, багасгах, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх нь хариуцлагатай аж ахуй нэгжүүдийн үндсэн зарчмуудын нэг болно.

“Эрдэс Холдинг” ХХК нь улс орон болон бүс нутгийн эдийн засгийн өсөлтөнд хувь нэмэр оруулахын зэрэгцээ нээлттэй байдал, тогтвортой хөгжлийг үнэт зүйлээрээ тодорхойлсон. Тиймээс байгаль орчны хамгааллын асуудалд тэргүүлэх ач холбогдол өгдөг.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаал болон бусад Монгол улсын хууль, журам, тогтоолын шаардлагад нийцүүлсэн бөгөөд компанийн 2024 оны төлөвлөгөөнд байгаль орчны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудыг төлөвлөн тусгасан.


Компани байгаль орчны асуудлуудыг албан ёсоор тодорхойлж тэдгээрийг шийдвэрлэх шат дараатай алхмуудыг бодлогын баримт бичигт тусгасан. Хог хаягдлын дахин боловсруулалтыг сайжруулах замаар байгальд хаях хог хаягдлын хэмжээг бууруулах, хүрээлэн буй орчинд учруулж байгаа сөрөг нөлөөллийг ялангуяа хөрс бохирдуулагчийг хянах зэрэг гол асуудлуудыг байгаль орчны гол шалгууруудаар тодорхойлсон.

Мөн 2024 оны эхний улиралд батлагдсан Аудитын тайлангийн дагуу ажлуудыг төлөвлөн ажиллана.

## 1. Төслийн товч танилцуулга

**Төслийн ажлын зорилго.** “Эрдэс холдинг” ХХК нь аялал жуулчлалын орчин үеийн, дээд зэрэглэлийн чанартай үйлчилгээ үзүүлдэг томоохон цогцолбор болгох зорилготой. Үүнтэй уялдуулан аялал жуулчлалын иж бүрэн цогцолборыг барьж ашиглалтад оруулах, гадаадын жуулчдыг хүлээн авах асуудлыг шийдэх замаар цогцолборын жигд үйл ажиллагааг хангана.

**Төслийн байршил.** Тус цогцолбор нь Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газарт



Эрээн уулын өвөрт Рашаантын амны эхэнд Гялалзахын энгэрт байрладаг.

### Зураг 1. Аялал жуулчлалын цогцолборын байршил

**Төслийн хүчин чадал.** “Намуун” аялал жуулчлалын цогцолбор нь нэг ээлждээ 82 хүн хүлээн авах хүчин чадалтай бөгөөд 2005 оноос эхлэн цогцолборын бүтээн байгуулалтын ажлуудыг хийсээр байна.

Дараах ажлууд хийгдсэн:

1. Зочдыг хүлээн авах тусгай байр
2. Өвлийн 5 сууц
3. Зочид буудлын 3 байшин
4. Ресторан, бар цэнгээний газар ( подвал, мансардтай)
5. Зуны цагт ашиглах каркасан хийцтэй сүүдрэвч
6. Ариун цэврийн байгууламж (халуун хүйтэн ус, шүршүүр, суултуур, писсауртай)
7. Үндсэн объектуудыг холбосон авто зам болон явган хүний зам
8. Авто зогсоолын талбай
9. Унд, ахуйн усыг хангах гүний худаг
10. Бохир усны татуургын шугам хоолой ба бохир усны цооног
11. Объектуудын хооронд усан цөөрөмтэй цэцэрлэгт хүрээлэн
12. Объектуудыг тойруулан 4 га талбайг хамруулсан төмөр сараалжин хашаа зэргийг өмнөх онуудад барьж байгуулсан.

Эдгээр жуулчид, амрагчдыг хүлээж авах барилга байгууламжууд нь бүгд халуун хүйтэн ус, бохирын шугамтай холбогдсон болно. Жилдээ 500-1200 хүнд үйлчлэх хүчин чадалтай байхаар төлөвлөсөн.



Зураг 2. “Намуун” АЖЦ-ын барилга байшингийн зураг

**Төслийн үндсэн барилга байгууламж, тоног төхөөрөмж.** Тус “Намуун” аялал жуулчлалын бааз хоногт 82 хүн хүлээн авч үйлчлэх хүчин чадалтай бөгөөд зочдыг хүлээн авах тусгай байр, жуулчид, амрагчдын тав тухыг хангасан өвлийн 5 сууц, зочид буудлын 3 байшин, ресторан ( подвал, мансардтай), зуны цагт ашиглах каркасан хийцтэй сүүдрэвч, ариун цэврийн байгууламж (халуун хүйтэн ус, шүршүүр, суултуур, писсауртай), гүний худаг, галын наадмын талбай, машины зогсоол зэрэг барилга байгууламжтайгаар үйл ажиллагаа явуулахаар бэлтгээд байна.

### **Төлөв байдлын товч тодорхойлолт**

Цогцолборын үйл ажиллагаа явагдаж буй талбай нь уулын ойт-хээрийн бүсэд багтах бөгөөд хойд хэсгээрээ боржингийн цохио хаднуудтай, урагшаа 4-6° орчим хэвгий өргөн хэсэгтээ 500 м орчим, 1 км орчим урт уулын амны хэсэг юм. Хамгийн өндөр цэг нь Дүнхэн уул 2120.2 м, Номт уул 2077.1 м болно.

Горхийн боржингийн массив нь зүүн хойш сунаж тогтсон, уртаараа 15 км, өргөнөөрөө 9 км хэмжээтэй, ерөнхийдөө өндөг хэлбэрийн биет юм. Массивын сунал нь зүүн хойшоо чиглэсэн, агуулагч чулуулагтайгаа 75-90°-аар огцом хиллэсэн биет байдаг. Аялал жуулчлалын цогцолбор байгуулахаар сонгосон Рашаантын амны эхэнд том мөхлөгтэй, тод шигтгээтэй саарал бор өнгийн боржин тархсан.

Газар хөдлөлийн идэвхшил MSK шатлалаар 7<sub>3</sub> балл хүртэл доргих бүсэд багтана.

### 2. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Төслийн болзошгүй нөлөөллийн үнэлгээнээс харахад байгаль орчинд төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх гол сөрөг нөлөөллийг тодорхойлбол:

- Хүмүүс олноор төвлөрөн бөөгнөрөх, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихсэх, үүнтэй уялдан хөрс дагтарших, эвдрэх, ургамал нөмрөг алдралд орох, улмаар хөрсний үржил шимт хэсэг устаж алга болох, механик бүрэлдэхүүн өөрчлөгдөх
- Хог хаягдлаа замбараагүй хаявал гадаргын ус болон хөрс, ургамал бохирдох
- Технологи үйл явцаа зөв зохион байгуулахгүй бол байгальд нөлөөлөх магадлалтай байна.
- Олон салаа зам гарах

Төслийн нөлөөллийг матрицын аргаар үнэлсэн дүнгээс дүгнэлт хийхэд байгаль орчинд сөрөг нөлөөлөл бага эрчимтэйгээр нөлөөлөх төслийн ангилалд багтах юм. Байгаль орчны бүрдэл хэсгүүдээс нөлөөлөлд өртөх гол бүрдэл хэсэг нь хөрс, ургамал байна. Иймд төслийн зөвлөмжид дурдсан болон хууль эрхзүйн баримт бичгийг байнга мөрдөн ажиллана.

Дээрх нөлөөллийн хүчин зүйлүүдээс хамгийн их нь хатуу хог хаягдал хур борооны усаар угаагдаж хөрсөнд шингэх, шатах тослох материал асгарах, аялагч амрагчдын хөл хөдөлгөөн ихсэх, тээврийн хэрэгслээр холхиж олон салаа зам гаргаснаас хөрс эвдрэх нь хөрс, усны бохирдол, ургамлан нөмрөг талхлагдаж биомассын хэмжээ багасах зэрэг сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

### 3. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт

Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах, талаар Монгол Улсын хуулиуд, шинээр гарч буй шаардлагатай уялдан байнга шинэчлэгдэж байх баримт бичиг төдийгүй төслийн хэрэгжилтийн үе шатанд байгаль хамгаалах, болзошгүй сөрөг нөлөөллийг тухай бүр нь бууруулах зорилтыг хангах үүрэгтэй юм.

Мөн төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага, зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар авах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгасан.

Иймд “Эрдэс Холдинг” ХХК нь байгаль орчинд ээлтэй үйд ажиллагаа явуулах зорилгын хүрээнд 2024 оны БОМТөлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах зорилготой.

4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Агаар орчин бохирдох	Авто зогсоолын талбайг нягтаршуулж тохижуулах	Авто зогсоолын талбай	м	Дотоод төлөвлөлт	1 удаа	Агаарын бохирдлын тухай хууль
2	Усан орчин	Усны тоолуурын ашиглалт, баталгаажуулалтын хугацааг хянах, шаардлагатай бол баталгаажуулах	Усны эх үүсвэрийн тоолуур	ш	100,0	1 удаа	Усны тухай хууль
3		Хурын усыг цуглуулах	Төслийн талбайд	м	Дотоод төлөвлөлт	Зуны улиралд	
4		Усыг аль болох бага ашиглах талаар сануулга мэдээлэл байршуулах	Амрагчдын сууц байр	Төг/ш	100,0	Тогтмол	

**2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэм-жих нэг	Нийт зардал, мян.төг	Хэрэг-жүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
5	Хөрсөн бүрхэвч	Амрагчдын техникийн бүрэн бүтэн байдлаас шалтгаалж авто зогсоол орчмоор ШТМ-аар бохирдсон үед яаралтай арга хэмжээ авах	Авто зогсоол	м	Дотоод төлөвлөлт	Тогтмол	Хог хаягдлын тухай хууль, Ургамалын тухай
6		Амрагчдыг чөлөөт зорчилт хийхгүй, зориулалтын маршрутаар явах, санамж, тэмдэг тэмдэглэгээ тавих	Төслийн талбайд	м	200,0	1 удаа	
7	Биологийн төрөл зүйл	Таримал ургамалуудыг тордох, услах	Төслийн талбайд	м	400,00	Хавар намарт	
8		Хэт чанга дуу чимээг хориглох, амрагчидад танилцуулах		м	50,0	Тогтмол	
9	Нийгэм эдийн засаг	Ариутгал цэвэрлэгээг тогтмол хийх	Амрах байр, гал тогоо ресторан	м2	240,0	Сар бүр	Ариун цэврийн тухай хууль
10		Хүнсний бүтээгдэхүүний хугацаа, аюулгүй байдлыг дагаж мөрдөх	Ажилчид амрагчид	ш	Дотоод төлөвлөлт	Тогтмол	Хүнсний бүтээгдэхүүний тухай хууль
11		Аюулгүй ажиллагааны сургалт	Нийт ажилчид	ш	Дотоод төлөвлөлт		ХАБЭА-н тухай хууль



**5. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө**

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэг	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Төслийн талбайн ургамалан нөмрөгийг арчилж тордох	Хогийн ургамалуудыг түүх	Төслийн талбайд	м2	0.5	5,10 сард	Таримал ургамалын үр сортын тухай
2.		Өмнөх жилүүдэд тарьсан суулгацуудыг усалж тордон, арчилгаа хийх		м2			
3.		Ургалт нь зогссон модыг зайлуулж нөхөн тарилт хийх		м2			
<b>Тэрбум модны хүрээнд</b>							
1	Аялал жуулчлалын цогцолборын талбайд	Мод тарих	30ш		5,7	10 сард	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, MNS 5918 : 2023

**6. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө**

Ашиглалтын талбайд одоогоор түүх соёлын дурсгалт зүйл илрээгүй болно.

1. ЮНЕСКО-ийн конвенцыг мөрдлөг болгон дурсгалт газрууд өнгөрсөн үеийн түүхийн дурсгалууд биет бус соёлын өвийн болох бүжиг, хөгжим, уламжлалт ахуй зэрэг соёлын олон янз байдлыг бий болгох гол хүчин зүйлсийг хадгалан үлдэх, судлах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх боломж чиглэлийг судлахад анхаарал хандуулан ажиллана.

**7. Осол эрсдлийн төлөвлөгөө**

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Гал түймрийн аюул	Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчидад тогтмол хугацаанд танилцуулах	Төслийн хэмжэээнд	Дотоод төлөвлөлт	2 удаа	Галын аюулгүй байдлын тухай хууль, 16-р зүйл, MNS 5566:2005 MNS 0640:89 MNS 639:89
2	Байгалийн гэнэтийн үзэгдэл аваар ослын үед	Анхны тусламжийн иж бүрэн хэрэгсэл хайрцагийг байрлуулах		500,0	1 удаа	
3	Байгалийн гэнэтийн үзэгдэл салхи, шуурга үерийн үед	Байгалийн гэнэтийн үзэгдэл салхи, шуурга үерийн үед			Тогтмол	Гамшигаас хамгаалах тухай хууль

**8. Хог, хаягдлын менежмент**

Намуун АЖЦ-ын үйл ажиллагаанаас бий болж буй хог хаягдлын хэмжээг багасгах аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах зарчмыг баримтлан ажиллана.

Бид 2024 онд хог хаягдлын менежментийг сайжруулах үүднээс ажилчидад сургалтыг тогтмол орж мэдээлэлийг тогтмол өгнө.

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хатуу хог хаягдал	Зориулалтын сав бэлдэх, ашиглах	Төслийн хэмжээнд	0,6	Үйл ажиллагаа жигдэрсэн үед сард	Хог хаягдлын тухай хууль, Дахин боловсруулах сэргээн ашиглах булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага
2		Хоолны үлдэгдэл	Гал тогоо, сууц		Тогтмол	
3						
4						
5						
6		Амрагчдад хог хаягдлын талаар анхааруулга санамж, тэмдэг байршуулах	Төслийн талбайд			
7	Шингэн хог хаягдал	Цэвэрлэх байгууламжын бүрэн бүтэн байдалд тогтмол хяналт тавих	Цэвэрлэх байгууламж	0,5		Улиралд 1 удаа
8		Ариун цэврийн байгууламж, бохирын худагт ариутгал хийх				
9	Дахин ашиглах хог хаягдал	Хүнсний сав багла боодол, ундаа, пиво лааз, засварын үйл ажиллагаанаас гарсан мод	Төслийн хэмжээнд		Тогтмол	Хог хаягдлын тухай хууль

**9.Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөө**

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Нэгжийн зардал, м/төг	Хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, арга, аргачлал
1.	Орчны хөрсөн дэх эмгэг төрүүлэгч бактерийн тоо	Амрагчдын байрны ойролцоо	49,0	Дулааны улиралд	MNS 5850:2008 MNS ISO 11074-1:2001 MNS 5546 : 2005
2.	Бохир ус цэвэршүүлэгчийн танкны ойр орчмоос	Цэвэрлэх байгууламжийн ойр орчмоос	70,0	Дулааны улиралд	Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
3.	Ундны усны бүрэн шинжилгээ	Гүний худгаас	49,0	2	MNS ISO 5667-10 : 2001 MNS ISO 5667-13 :2000
4.	Ундны усан дахь эмгэг төрүүлэгч бактерийн тоо	Усны цоргоноос	49,0	2	MNS 4586 : 1998 MNS 4943 : 2011 MNS-6148:2010

**10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө**

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2024 он				
			1 улирал	2-р улирал	3-р улирал		
1	Нийт ажилтаны ХАБЭА-н сургалт	Хамаарал бүхий бүх компанийн ажилчид жилд 1 удаа орно	-	-	11-р сар	Захирал, БОА	ХАБЭА-н тухай хууль, Гамшигаас сэргийлэх
2	Ус. Цахилгаан, Газрын төлбөр, БОХ-зардлуудыг жилийн төсөвт тусгах	1,5	Сар бүр	Сар бүр	Сар бүр	Захирал, БОА	
3	Хог хаягдлыг ангилан ялгах шаардлагыг бүрэн хангасан хогийн савыг төслийн талбайд байршуулах	250,0	-	-	8 сар	Захирал, БОА	Хог хаягдлын тухай хууль

**11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах**

БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, оролцогч талууд	Тайлагнах хэлэлцүүлэх хэлбэр Мэдээллийн агуулга		Хугацааны тов	Тайлагнах зардал, мян төг	Хариуцан зохион байгуулах ажилтан	Зохион байгуулах газар
ГТБЦГ-ын захиргаа, БОАЖЯ	Цахимд шивэх, тайлагнах	БОМТ-ийн биелэлт	11-р сард	Дотоод төлөвлөлт	БОА, Захирал	ГТБЦГ-ын захиргаа
	цахим		11-р сард			БОАЖЯ